



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

「Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхөөгүй боловч ашиглалтын шаардлага хангахгүй болсон, 19 нэрийн, нийт 40,065,010.05 (дөчин сая жаран таван мянга арван төгрөг таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 19,110,504.64 (арван есөн сая нэг зуун арван мянга таван зуун дөрвөн төгрөг жаран дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Б.Мөнхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг төрийн өмчит компанийн эзэмшилд хэвээр үлдээж, зориулалтын дагуу ашиглах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
132001268
9-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн
131 дугаар тогтоолын хавсралт

**"МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
Барилга, байгууламж						
1	Холбооны барилга-Увс аймгийн Тэс сум	1982-12-28	1	670,046.22	670,046.22	-
2	Холбооны барилга-Увс аймгийн Зүүнговь сум	1985-12-28	1	98,168.73	98,168.73	-
3	Дизелийн байр-Хөвсгөл аймгийн Тариалан сум	1992-01-01	1	162,486.00	162,486.00	-
4	Холбооны барилга-Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сум Могойн уурхай	1983-01-01	1	290,938.20	290,938.20	-
5	Холбооны барилга -Дархан-Уул аймгийн Сүмбэр сум	1986-12-29	1	1,991,072.74	1,991,072.74	-
6	Холбооны барилга-Дархан-Уул аймгийн Номгон сум	1987-12-29	1	1,563,577.79	1,563,577.79	-
7	Говь-алтай аймгийн 124-р станцын амрах байр	2001-04-01	1	105,000.00	105,000.00	-
8	Говь-алтай аймгийн 126-р станцын амрах байр-Говь-алтай аймаг	1990-01-10	1	702,200.48	702,200.48	-
9	Говь-алтай аймгийн 127-р станцын амрах байр-Говь-алтай аймаг	1990-01-10	1	702,200.48	702,200.48	-
10	Дизелийн барилга -Ховд аймгийн Үенч сум	1991-01-02	1	385,560.00	385,560.00	-
11	Холбооны барилга- Булган аймгийн Бугат сум	1976-01-16	1	5,819,737.52	2,238,360.60	3,581,376.92
12	Холбооны барилга-Дорноговь аймгийн Сүмбэр сум	1996-06-06	1	1,201,005.06	120,100.80	1,080,904.26
13	Телевизийн барилга-Завхан аймгийн төв	1980-06-13	1	7,857,075.15	3,273,781.20	4,583,293.95

№	Хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
14	Холбооны барилга-Сүхбаатар аймгийн Мөнххаан сум	1975-12-31	1	2,660,364.00	950,130.00	1,710,234.00
15	Уурын зуухны барилга-Увс аймгийн төв	2001-01-01	1	3,105,289.20	705,747.60	2,399,541.60
16	Холбооны барилга-Сүхбаатар аймгийн Асгат сум	1972-12-31	1	4,067,463.61	1,452,665.40	2,614,798.21
17	Холбооны барилга-Сүхбаатар аймгийн Уулбаян сум	1974-12-31	1	3,739,226.43	1,558,011.00	2,181,215.43
18	Дизелийн барилга-Сүхбаатар аймгийн Мөнххаан сум	1979-12-31	1	4,156,336.80	1,484,406.00	2,671,930.80
19	Холбооны барилга-Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум	1967-01-03	1	787,261.64	656,051.40	131,210.24
	Нийт дүн		19	40,065,010.05 (дөчин сая жаран таван мянга арван төгрөг таван мөнгө)	19,110,504.64 (арван есөн сая нэг зуун арван мянга таван зуун дөрвөн төгрөг жаран дөрвөн мөнгө)	20,954,505.41 (хорин сая есөн зуун тавин дөрвөн мянга таван зуун таван төгрөг дөчин нэгэн мөнгө)